



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/853

Булган сум

“Өвлийн аялал жуулчлал” хөтөлбөрийн уулзалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны II/04 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2.2.1 дэх заалт, 2023 оны “Булган аймгийн 2023 оны төсөв баталсан тогтоолд өөрчлөлт оруулах тухай” XVII/01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2023 оны “Хөтөлбөр төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг тодотгон батлах тухай” А/593 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Булган аймгийн Могод, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Тэшиг, Хангал сум, Хялганат тосгонд “Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх”, “1 жуулчин – 1 хонь” хөтөлбөрийн уулзалтыг 2023 оны 12 дугаар сарын 23-ны өдрөөс 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүртэл зохион байгуулсугай.

2. Дээрх уулзалтад шаардагдах 9,879,380 (есөн сая найман зуун далан есөн мянга гурван зуун ная) төгрөгийг аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

0323011028

Аймгийн Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 22-ны/ний өдрийн А/853 дүгээр/ дугаар захирамжийн хавсралт

“Өвлийн аялал жуулчлал” хөтөлбөрийн уулзалтад шаардагдах шатахууны зардал

№	Уулзалт хийх чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа /хоног/
1	Булган - Могод	180	1
2	Могод - Хишиг-Өндөр	120	
3	Хишиг- Өндөр – Булган	110	
4	Булган - Тэшиг	280	1
5	Тэшиг - Хутаг-Өндөр	180	
6	Хутаг-Өндөр – Булган	200	
7	Булган - Хялганат	200	1
8	Хялганат -Булган	200	
	Нийт	1470	3

№	Зардал	Зарцуулах	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	0001БУА	1470/100*22=325 л	4060	1,319,500
2	0003БУА	1470/100*22=325 л	2520	819,000
3	0043БУА	1470/100*20=294 л	2520	740,880
	Дүн			2,879,380